

Цэндийн Баттулга¹, Батдэлгэрийн Амгаланбат²¹ Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль, Ази судлалын тэнхим² Соёлын Өвийн Үндэсний Төв. Улаанбаатар. Монгол

Хар цагаан усны бичээс

Товчлол. Увс аймгийн Баруунтуруун, Зүүнхангай сумын зааг нутагт орших Хар цагаан усны бичээсийг 1981 онд анх академич Д.Цэвээндорж гуай илрүүлжээ. Бичээсийг тухайн үеийн гар хуулбар, гэрэл зурагт тулгуурлан унших боломж тун бага байсан байна.

Бид тус өгүүлэлд Хар цагаан усны Мөртийн цахир хаданд байх таван үсэг тэмдэгтээс бүтэх уг бичээсийг тайлж уншсан судалгааны үр дүнгээс танилцуулж байна. Уг бичээс нь 'ᠲᠦᠶᠠᠨ' ~ äsāṅ ärli ~ 'Эсэн газартай' буюу Амар амгалан газар нутаг бүхий, Эсэн энхийн газар нутагтай гэсэн утгатай юм.

Түлхүүр үг. Увс аймаг, Хар цагаан ус, Мөртийн цахир хад, руни бичиг

Battulga Tsend¹, Amgalanbat Batdelger²¹ Department of Asian Studies, Faculty of Humanities,
School of Arts and Sciences, National University of Mongolia² National Center for Cultural Heritage Mongolia. Ulaanbaatar, Mongolia

The Khar Tsagaan Us Inscription

Abstract. The Khar Tsagaan Us Inscription was originally found in 1981 by Academician D. Tseveendorj. It is situated at the boundary of the Baruunturuun and Züünkhangai soums of the Uvs province. Based on the manuscripts and photographs of the that time, there was virtually little opportunity to decipher the inscription. Therefore, the researchers went to the Khar Tsagaan Us more than once to look at the inscription but returned without finding them. That's the reason no one has read or figured out the inscription.

The inscription, which consists of five letters, is read, and translated as 'ᠲᠦᠶᠠᠨ' ~ äsāṅ ärli ~ 'There is a peaceful place'. Alternatively, the translation means "a land of peacefulness, a land of serenity."

Keywords. Uvs province, Khar Tsagaan Us, Mörtiin tsakhir khad, runic inscription

Увс аймгийн Баруунтуруун, Зүүнхангай сумын нутагт орших Их Тосон уулын урд биеэс эхтэй Хар Цагаан усны Мөртийн цахир хаданд таван үсэг тэмдэгт бүхий нэг мөр руни бичээс бий (Зураг 1).

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс 1981, 1982 онуудад Увс, Хөвсгөл аймгийн нутаг дахь Чандманы соёлын дурсгал судлах хээрийн шинжилгээний ангийн ажлын хүрээнд Д.Цэвээндорж гуай руни бичгийн гурван дурсгал илрүүлснээс [Цэвээндорж, 1981, 1982] Хар цагаан усны бичээсийн талаар тусгайлан мэдээ, өгүүлэл нийтлүүлээгүй ажээ. Харин Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутгаас илрүүлсэн Цахирын бичээс, Увс аймгийн Сагил сумын нутгаас илрүүлсэн Төмөр Цоргын бичээсийг судалгааны

эргэлтэд оруулах зорилгоор нийтлүүлж мэдээлсэн байна [Цэвээндорж, 1984].

Д.Цэвээндорж гуай 1997 онд намайг ШУА-ийн Түүхийн хүрээлэнд ажиллаж байх үед Хар цагаан усны бичээсийн гар хуулбар өгсөн боловч унших боломж тун багатай байсан юм. Сайн гарсан гэрэл зураг байх ёстой, хайх зав гарахгүй юм. Олдохоор нь чамд өгнө гэдэг байлаа. Хэдийгээр олон жил хойно боловч академич Д.Цэвээндорж гуай уншихыг санал болгож байсан Хар цагаан усны бичээсийг нийтлүүлж байгаадаа баяртай байна. Уг бичээсийг нүдээр үзэхгүйгээр гар хуулбар, тухайн үеийн гэрэл зурагт тулгуурлан унших боломжгүй байсаар өдий хүрсэн.

Хар цагаан усны бичээсийг үзэж судлахаар нэг бус удаа зорьсон ч олж үзээгүй билээ.

Тухайлбал, бид 1997 оны зун Увс аймаг явах аян замын зуур Хар цагаан усанд очиж бичээсийг гүймэг байдлаар хайсан боловч олж үзэж чадаагүй юм.

Д.Цэвээндорж гуай тэр үед Хар цагаан усны хадны зураг бүхий гурван толгойн чухам алинд нь бичээс байсныг нэгэнт арван хэдэн жил өнгөрсөн байсан учраас яг таг зааж чадахгүй байна гэж байсан билээ.

2019 онд МУИС-ийн Түрэг судлалын салбарын багш доктор Н.Гэрэлмаа, докторант Б.Өргөнбуян, Ц.Улаанаа нар Хар цагаан усны бичээсийг аян замын зуур дахин үзэхээр зорьсон боловч мөн олоогүй байна.

2022 онд “Соёлын өвийн үндэсний төв” болон “Titans pictures ХХК” хамтран хэрэгжүүлж буй “Монголын баялаг 330” төслийн хүрээнд археологич Б.Амгаланбат нарын бүрэлдэхүүнтэй баг Мөртийн Цахирын хадны зураг болон бичээсийг үзэж гэрэл зураг авч, бичлэг хийн баримтжуулсан билээ.

Хар цагаан усны голын хойд талд, нутгийн иргэдийн Мөртийн Цахир хэмээн нэрлэх дээрээ овоо бүхий үргэлжилж тогтсон цахир хаданд олон тооны туурайн тамга, буга, согоо, туулай зэрэг амьтдыг хонхойлон сийлсэн байх бөгөөд тэдгээр зургийн зүүн доод талд таван үсэг, тэмдэгтэй бичээс байрлана.

Бичээс эхийн сийрүүлгэ: 𐰽𐰺𐰾𐰸

Үсгийн галиг: s ᠡ r l i

Үгийн галиг: äsän ärli

Үгчилсэн орчуулга: Эсэн газартай

Дээрх галиг, орчуулгад тулгуурлан Хар цагаан усны Мөртийн цахир хаданд буй бичээсийг ‘Амар

амгалан газар нутаг бүхий’ буюу ‘Эсэн энхийн газар нутагтай’ хэмээн утгачлан оруулж болох байна (Зураг 2).


𐰽 äsän -эсэн, эсэн мэнд. Монголын руни бичгийн бага дурсгалуудаас Зүрийн овооны бичээс, Шаахар толгойн бичээст [Баттулга, 2005, 2020, 2022: 132–133] тус тус 𐰽 äsän гэх үг тохиолдож байна.

Зүрийн овооны бичээст ‘ᠰᠠᠬᠠᠬᠠᠷᠲᠤᠮᠤᠮᠤᠨ ᠰᠤᠯᠤᠯ ᠰᠤᠯ (~sol) [iduq] түркä: alp šul (~sol) bitidim äsän olurtim- Баатар Шул (Шол). [Ариун] оргилд баатар Шул (Шол) бичив би. Эсэн суув би (Эсэн мэнд нутаглаж байв би)’ [Аззаяа, 2020; Баттулга, 2022: 136–139; Кляшторный 1978; Шинэхүү 1977] гэж тэмдэглэсэн байдаг.


Газрын байрлалын хувьд, Тэсийн голын Зүрийн овооноос өдөрчийн газарт Хар цагаан ус бий. Өөрөөр хэлбэл, баруун зүг зорчих Тэсийн голын замаар явахад Зүрийн овоо, Хар цагаан усаар заавал дамжин өнгөрөх ба эртнээс сэрмүүн сэргэг бэлчээртэй, тунгалаг гол устай аян замаар явагсад морь малаа амрааж буудаллахад нэн таатай газар нутаг байсан нь лавтай.

Нутагласан, эсвээс үдэлж буудаллаж амарсан газар нутагтаа амар амгалан, эсэн мэнд байснаа тэмдэглэн үлдээдэг байсан бололтой.

𐰽𐰺 äᠷ +li – газартай, нутагтай, газар нутагтай. Эртний түрэг хэлний нэрээс нэр үг бүтээх +li / li дагавар нь уг юм бүхий буюу уг юм агуулагдаж буй гэсэн утга илтгэдэг. Күл тигиний гэрэлт хөшөөний зүүн талын зургаадугаар мөрд ‘ini+li äč+li- дүүтэй ахтай буюу ах дүүтэй; bäg+li bodun+li ноёнтой ардтай, засаг захиргаатай ардууд’; Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн өмнөд талд



Зураг 1. Хар цагаан усны дурсгал



Зураг 2. Хар цагаан усны бичээсний гэрэл болон гар зураг

‘tün+li kün+li- шөнөтэй өдөртэй буюу өдөржин шөнөжин’ гэх мэт Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудад тохиолдох цөөнгүй жишээ дурдаж болно.

Духын бууцын хоёрдугаар бичээст **ᠨᠠᠵᠢᠶᠡᠰᠢ** säbig äg orunqa - таатай газар оронд буюу газар орон гэх үгийг хоршин **ᠨᠠᠵᠢᠶᠡ** äg orun гэж бичсэн сонирхолтой баримт байна [Sir Gerard Clauson, 1972; Баттулга, 2023].

Кашгарын Махмутын толь бичигт ‘äg = yerin güneye bakan güneṣli taraḡi -газрын өмнөш харсан нарлаг тал’ [Kaşgarlı Mahmut, 1999: 187], ‘ärle = yurtluk, yurt tutulan yer- эх орон, орон нутаг, газар нутаг’ [Kaşgarlı Mahmut, 1999: 191] гэсэн утгатайг тэмдэглэжээ.

Хар цагаан усны бичээс Монголын руни бичгийн бага дурсгалын хамгийн түгээмэл төрөл болох ‘аян замын тэмдэглэл’-д хамаарах дурсгал юм.

Хар цагаан усны хадны зургийг академич Д.Цэвээндорж гуай судалж судалгааны эргэлтэд оруулсан байдаг. Тэрбээр “Увс аймгийн Баруунтуруун сумын төвөөс зүүн урагш 60 км орчимд Их Тосон уулын урд биеэс эхтэй Хар Цагаан ус хэмээх уулын жижиг горхи урсдаг. Горхийн дэнжид цагаан цайвар чулуулагт гурван жижиг толгой буй. Эдгээрийн баруун талын толгойн урдэрэгт олон тооны “туурай тамга” болон мал амьтдын дүрсийг хонхойлгон цоолборлож урласан байдаг. Хар цагаан усны хадны зураг нь олон арван туурай тамгыг дүрсэлснээрээ бусад хадны зургаас ялгагдах гол онцлогтой” [Гонгоржав, 1999: 56] гэж тодорхойлжээ.

Д.Цэвээндорж гуай “Хар цагаан усны хадны

зураг” эрдэм шинжилгээний өгүүлэл [Цэвээндорж, 1996] хэвлүүлснээс гадна “Монголын эртний урлагийн түүх” нэгэн сэдэвт бүтээлдээ Хар цагаан усны хадны зургийг голлох эх хэрэглэгдэхүүнээр ашигласан ажээ [Цэвээндорж, 1999: 117-120].

Хадны зургийн он цагт холбогдуулан “Хадны зургийн насыг тогтооход тэднийг үйлдсэн арга барил, зурсан дүрс зэрэг чухал үүрэгтэй байдаг. ... Олон тооны тамгыг хаднаа дүрсэлсэн нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Цэнгүнжавын Эх, Бага Муна, Цэцэрлэг сумын Хүүхдийн овоо, Модтой толгой, Цахир, Увс аймгийн Баруунтуруун сумын Хар цагаан ус зэрэг газрын хаданд байгаа бөгөөд анхаарууштай нь тэдгээр хаднаа ганц тамга тэмдгүүд бус тэдэнтэй хамт гахай, буга, адуу, хулан морин тэрэг, зэр зэвсэг, хүн зэргийн зургийг дүрслэх болсон байна. Энэ нь мезолитоос эхлэн олон тамгыг хаднаа цохин дүрсэлдэг байсан уламжлал хожим неолит, хүрэл болон төмөр зэвсгийн түрүү үед уламжлагдан баяжиж, улмаар ан амьтдын дүр чухал үүрэгтэй болсныг харуулж байна” [Цэвээндорж, 2020:155–157] гэж дурдсан байна.

Хар цагаан усны хадны зураг, нэн ялангуяа туурай тамга, тэдгээрийн үүсэл гарал нь хүн төрөлхтний эртний урлаг, соёл сэтгэлгээний түүхийг судлахад чухал ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ. Энэ далимд, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Цахирын хадны туурай тамга, буга, адуу зэрэг дүрслэл нь тун ижил нэг цаг үеийн дурсгал гэдэг нь тодорхой харагдахаас гадна Цахираас өдрийн газарт Зүрийн овоо, Зүрийн овооноос өдрийн газарт Хар цагаан усны дурсгал буйг дурдъя.

Ном зүй

Kaşgarlı Mahmut, 1999 - Kaşgarlı Mahmut. *Divanü Lugat-İt-Türk (Dizini): Vol. Cilt IV (Besim Atalay, Trans.). Türk Dil Kurumu Yayınları: 524.*

Sir Gerard Clauson, 1972 - Sir Gerard Clauson. *An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish. Oxford, At the Clarendon Press.*

Аззаяа, 2013 - Б.Аззаяа. Тариатын бичээснээ тохиолдох нэгэн хэллэг. Гадаад хэл соёл судлал, МУИС, ГХСС, №387 (17), 9–16. Аззаяа, 2020-Б.Аззаяа. Монголын руни бичгийн баруун бүсийн дурсгал, тэдгээрт холбогдох тамга: Завхан аймаг. Түрэг, Уйгур судлал - 2019, 12–25.

Баттулга, 2005 - Ц.Баттулга. Шаахар толгойн эртний бичгийн дурсгал (Судалгааны урьдчилсан дүнгээс). Эрдэм шинжилгээний бичиг, МУИС Монгол хэл соёлын сургууль, Боть XXV(248), 29–32.

Баттулга, 2020 - Ц.Баттулга. Монголын руни бичгийн бага дурсгал / The Small monuments of Mongolian Runic Inscription. Монгол Улсын Соёлын Яам; ШУА, Археологийн хүрээлэн; Түүх, Угсаатны зүйн хүрээлэн.

Баттулга, 2022 - Ц.Баттулга. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. I: Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн дурсгал.

Баттулга, 2023 - Ц.Баттулга. Духын бууцын хоёрдугаар бичээс. Хэвлэлтэд.

Гонгоржав, 1999 - Г.Гонгоржав. (Ed.). Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал(сэдэвчилсэн лавлах). Монголын Хүмүүнлигийн ухааны академи.

Кляшторный, 1978- С.Г.Кляшторный. Наскальные рунические надписи Монголии I. Тэс, Гурвалжин-ула, Хангыта-хат, Хэнтэй. Тюркологический сборник 1975, 151–158.

Цэвээндорж, 1981- Д.Цэвээндорж. 1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан хүрэл төмөр

зэвсгийн дурсгал судлах ангийн тайлан. ШУА-ийн Түүхийн хүрээлэн.

Цэвээндорж, 1982 - Д.Цэвээндорж. 1982 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан хүрэл төмөр зэвсгийн дурсгал судлах ангийн тайлан. ШУА-ийн Түүхийн хүрээлэн.

Цэвээндорж, 1984 - Д.Цэвээндорж. Новые памятники Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур цорго. *Studia Historica*, XVII(13), 124–126.

Цэвээндорж, 1996 - Д.Цэвээндорж. Хар цагаан усны хадны зураг. Монгол-Солонгосын Хамтарсан Эрдэм Шинжилгээ, IV, 305–312.

Цэвээндорж, 1999 - Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх.

Цэвээндорж, 2020 - Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх (Хоёр дахь хэвлэл).

Шинэхүү, 1977- Тэсийн эртний түрэг бичээсийг дахин нягталсан нь. *Studia Archaeologica*, Tom. VII(fasc. 9), 113–121.

Divanü Lugat - İt-Türk (Dizini): Vol. Cilt IV (Besim Atalay, Trans.). Türk Dil Kurumu Yayınları: 524.

Sir Gerard Clauson, 1972 - Sir Gerard Clauson *An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish. Oxford, At the Clarendon Press.*



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.